



ТӨВ АЙМАГ  
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 1104

Бүрэн сум

Халдварт өвчөөс урьдчилан сэргийлэх  
вакцин тарих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.(а) дахь заалт, 29.2 дахь хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын халдварт Дуут, Галзуу, Томуу, Сахуугийн вакциныг 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2021 оны 10 дугаар сарын 30-ны хооронд төлвөлгөөт хугацааны дагуу хийж дуусгахыг Мал эмнэлгийн нэгжийн эмч нарт, уг ажилд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (С.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

2. Мал бүхий иргэдтэй гэрээ хийж, халдварт өвчний вакциныг тарьж дуусгах ажлыг зохион байгуулж, өрхийн дэвтэрт хөтлөлт хийж, баталгаажуулах ажлыг Түмий, Баясгалан-Уул, Сайн Цохио, Арцат Баянгүн, Баялагсүрэг Баянтөхөм Хариуцлагатай Хувьцаат Компанийн малын эмч (Д.Цэрэндаваа, Б.Дэлгэрнасан, Д.Хасбазар, Л.Сарантуяа, Д.Оюунтуяа) нарт даалгасугай.

3. Тарилгын явцад хяналт тавьж, хүн хүчний тусламж үзүүлж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

410500270